

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН  
МЭДҮҮЛСЭН БУСАД ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХҮРЭЭНД  
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 04 дүгээр  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хуулийн төсөлд зөвхөн алслагдсан цэргийн анги, салбарт ажиллаж байгаа цэргийн алба хаагчдын асуудал хөндөгдөж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан дотооддоо болон гадаадын улс орнуудад батлан хамгаалахын чиглэлээр цэргийн академи, их, дээд сургуулиудад суралцаж байгаа оюутан, сонсогч, офицер, ахлагч нарт суралцах хугацаанд нь үндсэн цалин, тэтгэлгийг нь 100 хувь олгох зохицуулалт байгаа эсэх, дотоодод суралцагчдын суралцсан хугацааг ажилласан жилд нь оруулан тооцдогтой адил гадаадад суралцагчдыг хэрхэн тооцож байгааг тодруулан асуулт асууж, хариулт авсан бөгөөд цаашид алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарын жагсаалт, холбогдох журмыг шинэчлэх шаардлагатай гэсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн уг хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарын жагсаалтыг хуулиндаа тодорхой заах, алслагдсан гэсэн ухагдахуундаа тулгуурлан хуулийн нэр томъёог зөв тодорхойлох нь зүйтэй талаар санал хэлж, өөр бусад хуульд дээрх нэр томъёог ашигладаг эсэхийг тодруулж асуусан.

Хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.ЭНХ-АМГАЛАН**